



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ САНАЛ ХУРААЛТАД БЭЛТГЭХ БОЛОН ГАРЧ БОЛОХ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

АГУУЛГА

- Санал хураалтын үйл явцын дараалал
- Саналын хайрцаг угсрах
- Санал тоолох төхөөрөмжийг саналын хайрцагт суурилуулах
- Тэжээлийн залгуур болон нөөц тэжээлийг төхөөрөмжид залгах
- Санал тоолох төхөөрөмжийг асаах, санал хураалт нээх, ТЭГ тайлан хэвлэх
- Саналын хуудас уншуулах, саналын хуудасны тэмдэглэгээ
- Санал тоолох төхөөрөмжийг цэвэрлэх
- Санал хураалт хаах, тайлан хэвлэх
- Санал хураалтын дүнг дамжуулах
- Санал тоолох төхөөрөмжөөс зурган файлыг хуулах
- СТТ-ийг унтрааж зөөврийн цүнхэнд хийх



САНАЛ ХУРААЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ДАРААЛАЛ

- 07:00 цагаас өмнө саналын хайрцаг, Санал тоолох төхөөрөмжийг иж бүрдлийн хамт угсарч бэлдсэн байна.
- Саналын хайрцгийг хэсгийн хорооны бүрэлдэхүүн болон ажиглагч нарт хоосон эсэхийг шалгуулна.
- Санал тоолох төхөөрөмжийн огноог шалгана.
- Санал хураалтыг 07:00 цагт /Улаанбаатарын цагаар/ нээнэ.
- Тэг тайлан хэвлэнэ.
- Зөөврийн саналын хайрцгийн саналын хуудсыг уншуулна.
- Бүртгэлийн хуудас авсан сонгогчид санал өгч дууссаны дараа санал хураалтыг хаана.
- Санал хураалтын үр дүнгийн тайланг хэвлэж өгнө.
- Санал хураалтын дүнг дамжуулна.
- Саналын хуудасны зурган мэдээллийг хуулбарлан өгнө.

Саналын хайрцаг угсрах үед

1

- Саналын хайрцаг угсрах явцыг ажиглагчдад харуулах болон тайлбарлах

2

- Нарны шууд тусгал тусахгүй газарт байрлуулах

3

- Хивсэн дээр байрлуулахгүй

4

- Сүлд тэмдэг урд талд байрлуулах

5

- Туслах тасалгааны лац
- хөндөгдөөгүй байна



САНАЛЫН ХАЙРЦАГ УГСРАХ



- Саналын хайрцгийн доод суурийг тэгш шалан дээр байрлуулна. Зэс наалт бүхий хэсэг нь урагшаа харах ёстой. Суурины дээд талыг чийгтэй материалаар цэвэрлэнэ.
 - Хайрцагны их биеийг босгож дэлгэнэ.
 - Хайрцгийн их биеийн доод хэсгийн дөрвөн талд байрлах лацдах зориулалт бүхий хоёр нүхийг суурины нүхнүүдтэй тааруулан байрлуулна.
 - Суурь болон их биеийг холбон дөрвөн талд нь зориулалтын лацаар чангалан суурилуулна.
 - Их биен дээр саналын хайрцагны тагийг суурилуулна.
- АНХААР:** Төхөөрөмж саналын хуудас уншаад доош унах хэсгийн амыг саналын хайрцгийн туслах тасалгаа байрлах тал руу буюу хайрцгийн нүүр тал руу харуулан тагаа байрлуулаарай.
- Хайрцгийн их биеийн дээд дөрвөн тал болон тагны дөрвөн талд байрлах хос нүхнүүдэд үлдсэн дөрвөн лацаа хийж чангална.

САНАЛЫН ХАЙРЦАГ УГСРАХ



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ САНАЛЫН ХАЙРЦАГТ СУУРИЛУУЛАХ



СТТ-г суурилуулна



Туузан улаан лац наах



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ АСААХ

Тэжээлийн үүсгүүрийн талаар

1. СТТөхөөрөмжид нөөц батерей, хувьсах тэжээлийг 2-ууланг нь залгах
2. Батерейн холбогчийг холбохдоо туйлыг /+,-/ солихоос урьдчилан сэргийлэх
3. Батерейг СТТөхөөрөмжид зөв залгах



НӨӨЦ БАТАРЕЙН ХОЛБОГЧИЙГ ХОЛБОХ



Залгуурын улаан толгойтой
эргийг (+) туйлд холбоно.



Залгуурын хар толгойтой
эргийг (-) туйлд холбоно.



АНХААРУУЛГА: (+) болон (-) туйлыг зөрүүлж холбож болохгүй

ХУВЬСАХ ТЭЖЭЭЛИЙГ ТӨХӨӨРӨМЖИД ХОЛБОХ

СТТ унтарч ассан тохиолдол:

- Цахилгааны уртасгагч хөндийрснөөс
- Цахилгаанжилт үүссэнээс



Урьдчилан сэргийлэх


Тэжээлийн залгуур хувиргагчийг хэрэглэх
СТТ-н уртасгагчид зөвхөн СТТ-г залгах




Санал тоолох
төхөөрөмжийг асаах,
санал хураалт нээх,
ТЭГ тайлан хэвлэх




САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ АСААХ




СТТ-г асаана



Дуут дохио өгнө






Хамгаалалтын түлхүүр




Нууц кодыг хийнэ

САНАЛ ХУРААЛТ НЭЭХ




Өгөгдөл дамжуулах туршилтын өдөр
Саналын тоог *Тэглэсэн* эсэхээ шалгах


Огноо тохиргоо



Удирдлагын цэс





ТЭГ ТАЙЛАН





Систем бэлэн

САНАЛЫН ХУУДАС УНШУУЛАХ





1. Санал тоолох төхөөрөмжийн дэлгэцэн дээр **“САНАЛЫН ХУУДАС УНШИХАД БЭЛЭН”** гэсэн мэдээлэл гарна.
2. Санал тоолох төхөөрөмжийн ховил руу саналын хуудсыг хийж уншуулна.
3. Ингэснээр санал тоолох төхөөрөмж саналын хуудас уншина, хэрэв ямар нэг алдаа гараагүй бол **амжилттай уншигдсан** мэдээлэл LCD дэлгэц дээр гарна.

САНАЛЫН ХУУДАСНЫ ТЭМДЭГЛЭГЭЭ ЗУРАГ ӨӨРЧЛӨХ






САНАЛЫН ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЦЭВЭРЛЭХ

- Санал тоолох төхөөрөмжийн иж бүрдэлд цэвэрлэх хуудас дагалдана
- Цэвэрлэх шингэн: $>70\%$ (этилийн спирт)





САНАЛЫН ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЦЭВЭРЛЭХ



- Соронзон түлхүүрийг байрлуулан **Удирдлагын цэс** гаргана.
- Этилийн спиртийг улаан шугамын 2-3 см-ийн өргөнтэйгөөр 2 тал тус бүрт уусгана
- Илүүдэл спиртийг агаарт 3-4 удаа сэгсэрч арилгана
- Саналын хуудасны оролтын ховилд А-В цэгийн хооронд 5-7 удаа гүйлгэнэ
- Цуцлах сонголтыг сонгож санал хураалтын горим шилжинэ.

Цэвэрлэсний дараа 2 минут хүртэлх хугацаанд СТТөхөөрөмжид саналын хуудас уншуулахгүй байх

САНАЛЫН ХУРААЛТ ХААХ



1. Удирдлагын цэсийг гаргахын тулд хамгаалалтын соронзон түлхүүрийг байрлуулна.

2. “САНАЛ ХУРААЛТ ХАА” товчийг дарна.

3. Нууц код оруулах дэлгэцэд кодоо хийж **НЭВТРЭХ** товчийг дарна.

4. Баталгаажуулах дэлгэцэд “**ТИЙМ**” товчийг дарна.

5. Дэлгэц дээр “**САНАЛ ХУРААЛТЫГ ХААЖ БАЙНА. ТҮР ХҮЛЭЭНЭ ҮҮ**” гэсэн мэдээлэл хэсэг хугацаанд харагдсаны дараа санал тоолох төхөөрөмжөөс үр дүнгийн тайлан шууд 1 хувь хэвлэгдэнэ.

6. Санал тоолох төхөөрөмж нь “**УГ ТАЙЛАНГ ДАХИН ХЭВЛЭХ ҮҮ?**” гэж асуухад санал авах байранд байх ажиглагчдын тоогоор болон санал авах байрны албан ажлын хэрэгцээнд шаардлагатай тоогоор “**ТИЙМ**” товчийг дарж хэвлэж өгнө.

- Хамгийн сүүлийн хувийг даамал өөртөө хэвлэж авна.
- Тайланг хэвлэж дууссаны дараа “**ҮГҮЙ**” товчийг дарсны дараа төхөөрөмж санал хураалтын дүн дамжуулах ажиллагааг эхэлнэ.

САНАЛЫН ХУРААЛТЫН ДҮН ДАМЖУУЛАХ



GSM буюу Мобиком, Юнителийн модем



MobiCom



UNITEL

1. Холбогч кабелийн **цэнхэр** толгойтой үзүүрийг модемд, **шар** толгойтой үзүүрийг санал тоолох төхөөрөмжид /Ethernet порт/ залгана.
2. Кабелийн 2 үзүүр нь хоёулаа портуудад гүйцэд орсон эсэхийг сайтар шалгана уу. Холболт дутуу хийгдсэн тохиолдолд дүн дамжихгүй.



Санал тоолох төхөөрөмж



RJ-45 кабель



Cell-Go (GSM)
өгөгдөл дамжуулах модем



Тэжээлийн гэрэл: **ногоон**
GSM сүлжээний гэрэл:
анивчсан улаан

Дамжуулалт: **улбар**
шар



АНХААР: Дээрх зурагт үзүүлсний адил Жи-Мобайлын модемыг асааснаас хойш 5 минутын дараа СТТ-тэй холбон өгөгдлөө дамжуулна.

Дүн амжилттай дамжсан тохиолдолд тайлан автоматаар хэвлэгдэнэ.



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ УНТРААЖ ЗӨӨВРИЙН ЦҮНХЭНД ХИЙХ

Удирдлагын цэс

ХААСАН

УДИРДЛАГЫН ЦЭС

ДАХИН НЭЭХ

ТУСЛАХ ЦЭС

ДҮНГ ДАХИН ДАМЖУУЛАХ

УНТРААХ

ЦУЦЛАХ

НИЙТ САНАЛ ТОО8

Баталгаажуулалт

ХААСАН

ТА ТӨХӨӨРӨМЖИЙГ
УНТРААХДАА
ИТГЭЛТЭЙ БАЙНА УУ?

ТИЙМ

ҮГҮЙ

НИЙТ САНАЛЫН8

Санал тоолох төхөөрөмжийг саналын хайрцгаас салган, дагалдах иж бүрдлийн хамт хамгаалалтын цүнхэнд хийнэ.




САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖӨӨС ЗУРГАН ФАЙЛЫГ ХУУЛАХ

Санал хураалтын дүнг дамжуулсны дараа төхөөрөмжөөс саналын хуудасны зурган файлыг хуулбарлаж авахдаа санал тоолох төхөөрөмжийг унтрааж зөвхөн **Poll worker** талын лацыг хөндөж **CF** картыг авч карт уншигчид хийнэ.

Карт уншигчийг сонгогчийн бүртгэлийн зөөврийн компьютерт холбож Мэдээллийн технологийн даамлын гарын авлага дахь зааврын дагуу зурган файлыг хуулж өгнө.

Зурган файлыг хуулсны дараа CF картыг соронзон түлхүүрийн хамт дугтуйнд хийж цүнхэнд хийнэ.



**АНХААРАХ
ЗҮЙЛС ГАРЧ
БОЛОХ
АСУУДАЛ,
ШИЙДВЭРЛЭХ
АРГА ЗАМ**

- Өгөгдөл дамжуулах туршилтын өдөр анхаарах зүйлс
- Санал хураалтын үед гарч болзошгүй АЛДАА
 - Санал тоолох төхөөрөмжийг асаах
 - Санал хураалт нээх, хаах, тайлан хэвлэх
 - Санал хураалтын явцад
 - Санал хураалтын дүн дамжуулах
 - Бусад

ДАРААХ ЗОРИЛГООР ӨГӨГДӨЛ ДАМЖУУЛАХ ТУРШИЛТЫГ ХИЙДЭГ

СТТ гэмтэлгүй хүргэгдсэн эсэхийг шалгах

СТТ зөв хэсгийн хороонд хүргэгдсэн эсэх

СТТ-ийн хэвийн ажиллагааг шалгах, дүн дамжуулах

Мэдээллийн технологийн даамлыг дадлагажуулах

*Өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн **ЗААВАР**-ыг МТТ-өөс гаргана.*

ӨГӨГДӨЛ ДАМЖУУЛАХ ТУРШИЛТЫН ӨДӨР АНХААРАХ ЗҮЙЛС

Өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн **ЗААВРЫН
ДАРААЛАЛ**—ын дагуу тэмдэглэл үйлдэнэ.

/Зааврыг Мэдээллийн технологийн төвөөс гаргана /

- Өгөгдөл дамжуулах туршилтын өдөр ашиглах дугтуйнд буй **“НУУЦ КОД”**-ыг оруулан туршилтыг нээж, хааж, **ТЭГЛЭНЭ**.
- ТУРШИЛТЫН саналын хуудсыг ТӨХӨӨРӨМЖ тус бүрт зөвхөн **НЭГ УДАА** уншуулна.
- Дүнгээ **НЭН ДАРУЙ** дамжуулна.
- Дүн дамжуулсны дараа **ТЭГЛЭХ**.

- Энэ өдөр **Санал тоолох төхөөрөмжийн ажиллагааг** зөвхөн Мэдээллийн технологийн ДААМАЛ бие даан өөрөө хийж гүйцэтгэх.
- Хэсгийн хорооны гишүүд болон ажиглагчдыг туршилтын явцад оролцуулахгүй байх
- Зааварт байхгүй үйлдэл хийхийг хориглоно.




САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ АСАХ ҮЕД ГАРАХ АЛДАА

Соёмбо тэмдэг 3 минутаас дээш байх

Шалтгаан: Тээвэрлэлтийн явцад санах ойн картууд үүрнээсээ суларсан байх магадлалтай

Шийдвэрлэх:

- СТТ-ийг унтраах
- Санах ойн үүрний лацуудыг хөндөж, картуудыг сайтар түлхэж өгнө.
- СТТ-ийг асаана.
- Лацдах шаардлагатай.



СЕХ-ны Мэдээллийн технологийн төвд болон МТ-ийн багт мэдэгдэн, зөвшөөрөл авах шаардлагатай

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ АСАХ ҮЕД ГАРАХ АЛДАА

*Тээвэрлэлтийн явцад санах ойн
картууд үүрнээсээ суларсан*

Шийдвэрлэх:

- Хэрэв **IGNORE /shutdown/** сонголт байвал сонголтыг дарж үргэлжлүүлэх
- СТТ-ийг унтраах
- “**Administrator**” үүрний лацыг хөндөж, картыг сайтар түлхэж өгнө.
- СТТ-ийг асаана.
- Лацдах шаардлагатай.



СЕХ-ны Мэдээллийн технологийн төвд болон МТ-ийн багт мэдэгдэн, зөвшөөрөл авах шаардлагатай

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ АСАХ ҮЕД ГАРАХ АЛДАА

Нууц код хийж болохгүй байх

1. Дэлгэц дээр дарахад ямар нэгэн хариу үзүүлэхгүй байх, нэг товчлууур дарахад давхар буруу товч дарагдах
/Мэдрэгч гадаргуун тохиргоо/
2. Дэлгэц хэтэрхий бүдэг байх
/Ялгарлын тохиргоо/



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ АСАХ ҮЕД ГАРАХ АЛДАА

Мэдрэгч гадаргуун тохиргоо хийх

- СТТөхөөрөмжийг унтраана.



Cast, Return
товчийг зэрэг
дараастай СТТ-
ийг асаана



Тодорхойгүй
бужигнасан
дэлгэц гарна




Байнд нарийн үзүүртэй /металл биш/
зүйлээр дарж тохируулна



САНАЛ ХУРААЛТЫГ НЭЭЖ, ХААХАД ГАРАХ АЛДАА

1 | Соронзон түлхүүрийн алдаа “Error reading security key”



2 | Соронзон түлхүүрийн алдаа “Incorrect Security Key”

Шалтгаан: Буруу түлхүүр дарагдсан

Шийдвэрлэх:

- Хэрэв 2 СТТ-тэй бол соронзон түлхүүрийг хооронд нь солисон эсэхээ нягтлах
- СЕХ-ны Мэдээллийн технологийн төвд болон МТ-ийн багт мэдэгдэх

Соронзон түлхүүрийн их бие хэсэгт хурууны өндгөө байрлуулан хамгаалалтын түлхүүр унших ховилд жигд хүчээр дарна.


- Соронзон түлхүүр нь зөвхөн тухайн СТТ-д ашиглах боломжтой байдаг учир хаяж гээгдүүлэхээс болгоомжлох !!!
- Үнэмлэхний зүүлтэд хамтад нь зүүх !!!

САНАЛ ХУРААЛТЫГ НЭЭЖ ХААХАД ГАРАХ АЛДАА

Огноо тааруулах



Он, Сар,
Өдөр, Цаг,
Минут
Дарааллаар
тохируулах



+++ Нэгээр нэмнэ
--- Нэгээр хасна
Дууссан

САНАЛ ХУРААЛТЫГ НЭЭХЭД ГАРАХ АЛДАА

Хэрэв дүн тэглэгдээгүй байвал:

- “Санал Хураалт Нээ” сонголтын оронд “**Дахин нээх**” сонголт гарч ирнэ
- Төлөвийн тайлан хэвлэхэд ТЭГ БИШ байна
- Дэлгэцийн доод талын уншуулсан саналын тоо ТЭГ БИШ байна

The screenshot shows a web application interface with a black border. At the top left is a power icon and the text "ХААСАН". Below this is the title "УДИРДЛАГЫН ЦЭС". The main content area contains three buttons: "ДАХИН НЭЭХ", "ТУСЛАХ ЦЭС", and "ДҮНГ ДАХИН ДАМЖУУЛАХ". At the bottom are two buttons: "УНТРААХ" and "ЦУЦЛАХ". The footer shows "НИЙТ САНАЛ ТОО" and the number "8".

ХААСАН	
УДИРДЛАГЫН ЦЭС	
ДАХИН НЭЭХ	
ТУСЛАХ ЦЭС	
ДҮНГ ДАХИН ДАМЖУУЛАХ	
УНТРААХ	ЦУЦЛАХ
НИЙТ САНАЛ ТОО	8

Өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн зааврын дагуу Тэглээд, үйл ажиллагааг үргэлжлүүлэх

ТАЙЛАН

- Тэг тайлан - *Санал хураалт нээхэд*
- Төлөвийн тайлан – *Санал хураалтын явцад*
- Санал хураалтын хаалтын тайлан – *Санал хураалтын үр дүн*
- Дүн дамжуулсан тайлан – *Өгөгдөл дамжуулсны дараа*



САНАЛ ХУРААЛТЫН ЯВЦАД ГАРАХ АСУУДАЛ



СТТ САНАЛЫН ХУУДАС БУЦААХ ТОХИОЛДОЛ:

Тодорхой бус тэмдэглэгээ

Мандатын тооноос илүү тэмдэглэгээ хийсэн

Гэмтэлтэй саналын хуудас

Өөр тойргийн болон хүчингүй саналын
хуудас

Сканер бохирдсон



САНАЛ ХУРААЛТЫН ЯВЦАД ГАРАХ АСУУДАЛ

СТТ саналын хуудас унших :

Мандатын тоотой ТЭНЦҮҮ
Мандатын тооноос дутуу
ХООСОН саналын хуудас



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ САНАЛЫН ХУУДАС БУЦААХ ТОХИОЛДОЛ

- Санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг уншихгүй байх хэд хэдэн тохиолдол байдаг. Тухайлбал саналын хуудас болон санал тэмдэглэгээ, саналын хуудас санал тоолох төхөөрөмжийн тохиргооноос хамаардаг.
- Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн Санал тоолох төхөөрөмжийн программ хангамжийг тохируулдаг.


Саналын хуудас уншуулах үед санал тоолох төхөөрөмж дараах алдаануудыг илрүүлнэ

- Саналын хуудсан дахь тодорхой бус тэмдэглэгээ
- Мандатын тооноос илүү хийсэн тэмдэглэгээ
- Мандатын тооноос дутуу хийсэн тэмдэглэгээ
- Гэмтэлтэй саналын хуудас
- Өөр тойргийн болон өөр санал авах байрны саналын хуудас
- Батлагдсан загвараас өөр, шаардлага хангаагүй саналын хуудас.

ДААМАЛ: Алдааны мэдээллийг оношлохдоо СТТ-ийн дэлгэцийн мэдээллийг харна.
Сонгогчийн саналын хуудсыг харахыг хориглоно.

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ САНАЛЫН ХУУДАС БУЦААХ ТОХИОЛДОЛ

❑ ТОДОРХОЙ БУС ТЭМДЭГЛЭГЭЭ




Сонгогч улаан дугуйг дүүргэн будна.



- *Тодорхой бус тэмдэглэгээ*



- *Мандатын тооноос **илүү** болон **дутуу** тэмдэглэгээ хийсэн*




Сонгогчид саналаа гүйцэд тэмдэглэх боломжийг олгоно

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ САНАЛЫН ХУУДАС БУЦААХ ТОХИОЛДОЛ

- Гэмтэлтэй саналын хуудас
- Өөр тойргийн болон өөр санал авах байрны саналын хуудас
- Батлагдсан загвараас өөр, шаардлага хангаагүй саналын хуудас.

*Төхөөрөмжийн дэлгэцэд “Хүчингүй саналын хуудас” гэсэн анхааруулга 5 секундийн турш харагдах бөгөөд сонсогдохуйц **ДУУТ ДОХИО** өгнө.*

Энэ үед даамал ямар нэгэн үйлдэл хийлгүй хүлээхэд төхөөрөмж санал хураалтын хэвийн горимд шилжинэ.



САНАЛЫН ХУУДАС ГАЦАХ

ХААСАН	
ЦААСНЫ БӨӨГНӨРӨЛ ИЛЭРЛЭЭ (ОРОХ ЗАВСАР) ДҮН ХАДГАЛАГДААГҮЙ. БӨӨГНӨРЛИЙГ ЦЭВЭРЛЭНЭ. САНАЛЫН ХУУДСЫГ САНАЛЫН ХАЙРЦАГТ ХИЙЖ БОЛОХГҮЙ. БЭЛЭН БОЛСНЫ ДАРАА 'ЦЭВЭРЛЭСЭН' ТОВЧИЙГ ДАРНА.	
ЦЭВЭРЛЭСЭН	
НИЙТ САНАЛ ТОО	8

ХААСАН	
ЦААСНЫ БӨӨГНӨРӨЛ ИЛЭРЛЭЭ (ГАРАХ ЗАВСАР) ДҮН ХАДГАЛАГДСАН. БӨӨГНӨРЛИЙГ ЦЭВЭРЛЭЭД, САНАЛЫН ХУУДСЫГ САНАЛЫН ХАЙРЦАГТ ХИЙНЭ. БЭЛЭН БОЛСНЫ ДАРАА 'ЦЭВЭРЛЭСЭН' ТОВЧИЙГ ДАРНА.	
ЦЭВЭРЛЭСЭН	
НИЙТ САНАЛ ТОО	8

*Саналын хуудас унших
ховилд цаасны бөөгнөрөл
үүссэн тухай мэдээлэл*

*Саналын хуудас уншигдаад
гарах үед хойд ховилд үүссэн
цаасны бөөгнөрлийн тухай
мэдээлэл*

**Цаасны бөөгнөрлийг арилгахдаа дараах
дарааллаар ажиллагааг хийж гүйцэтгэнэ:**

- 1) Гацсан саналын хуудсыг автоматаар буцаан гаргахын тулд “ЦЭВЭРЛЭСЭН” товчийг дарна.
- 2) Хэрэв саналын хуудас ямар нэг гэмтэлгүйгээр төхөөрөмжөөс гарч ирсэн бол түүнийг төхөөрөмжид дахин уншуулж болно.
- 3) Хэрэв санал тоолох төхөөрөмж саналын хуудсаа буцаан гаргахгүй бол 1 дүгээр алхам руу буцна.

САНАЛЫН ХУУДАС ГАЦАХ

- Өмнөх саналын хуудсыг уншиж хараахан дуусаагүй байхад / **Заавал САНАЛЫН ХУУДСЫГ УНШИХАД БЭЛЭН үед уншуулах !!!!!!! /**
- Үрчийсэн болон нугаларсан саналын хуудас хийснээс

ХААСАН	
“ЦААСНЫ БӨӨГНӨРӨЛ ХЭВЭЭР БАЙНА. ‘УНТРААХ’ ТОВЧИЙГ ДАРААД, БӨӨГНӨРЛИЙГ ЦЭВЭРЛЭНЭ ҮҮ. ДҮН ХАДГАЛАГДААГҮЙ ТУЛ САНАЛЫН ХУУДСЫГ САНАЛЫН ХАЙРЦАГТ ХИЙЖ БОЛОХГҮЙ.” УНТРААХ НИЙТ САНАЛ ТОО 8	“ЦААСНЫ БӨӨГНӨРӨЛ ХЭВЭЭР БАЙНА. ‘УНТРААХ’ ТОВЧИЙГ ДАРААД, БӨӨГНӨРЛИЙГ ЦЭВЭРЛЭНЭ ҮҮ. ДҮН ХАДГАЛАГДСАН ТУЛ САНАЛЫН ХУУДСЫГ САНАЛЫН ХАЙРЦАГТ ХИЙНЭ ҮҮ.” УНТРААХ НИЙТ САНАЛ ТОО 8

Цаасны бөөгнөрөл хэвээр үед дэлгэцэд гарах мэдээлэл

4. Хэрэв санал тоолох төхөөрөмжөөс саналын хуудсаа буцаан гаргах үйлдлийг 4 удаагийн оролдлогоор гүйцэтгэж чадаагүй бол LCD дэлгэцийн баруун доод буланд “УНТРААХ” гэсэн товчтой “ЦААСНЫ БӨӨГНӨРӨЛ ХЭВЭЭР БАЙНА” гэсэн мэдээлэл гарна.

5. “УНТРААХ” товчийг дарж санал тоолох төхөөрөмжийг унтраана.

6. Хэрвээ саналын хуудас төхөөрөмжийн ар болон урд талаас, эсхүл чиглүүлэгч үүрнээс ил гарсан харагдаж байвал саналын хуудсыг гараараа татаж авч болно.

7. Унтраасан санал тоолох төхөөрөмжийг залгуураас нь салгаснаас хойш 5 секунд болсны дараа дахин тэжээлд залгаснаар төхөөрөмжийн ажиллагааг дахин эхлүүлнэ.

8. Хэрвээ саналын хуудас гацсан хэвээр байгаа бол Мэдээллийн технологийн багийн гишүүд болон Мэдээллийн технологийн төвтэй холбоо барина.

СКАНЕР БОХИРДОХ

Санал тоолох төхөөрөмжийн сканерын эд анги бохирдсон тохиолдолд саналын хуудсыг уншихгүй буцаан гаргавал төхөөрөмжийн иж бүрдэлд дагалдах цэвэрлэгээний хуудас болон шингэнийг ашиглаж саналын хуудас унших замыг цэвэрлэнэ.




Саналын хуудас унших замыг цэвэрлэгээний хуудсаар цэвэрлэхэд дараах зүйлс шаардлагатай. Үүнд:

- Цэвэрлэгээний хуудас
- Цэвэрлэх шингэн: >70%
Этанол (этилийн спирт)



СКАНЕР БОХИРДОХ

Санал тоолох төхөөрөмжийн сканер 2 талаараа уншдаг тул дээд талын толгой бохирдсон тохиолдолд доод талын сканераар Саналын хуудсыг үргэлжлүүлэн уншуулах боломжтой. 2 тал 2-аа уншихгүй болсон тохиолдолд СТТ-ийн сканерын бохирдлыг зааврын дагуу цэвэрлэнэ.



- Соронзон түлхүүрийг байрлуулан **Удирдлагын цэс** гаргана.
- Этилийн спиртийг улаан шугамын 2-3 см-ийн өргөнтэйгөөр 2 тал тус бүрт уусгана
- Илүүдэл спиртийг агаарт 3-4 удаа сэгсэрч арилгана
- Саналын хуудасны оролтын ховилд А-В цэгийн хооронд 5-7 удаа гүйлгэнэ
- Цуцлах сонголтыг сонгож санал хураалтын горим шилжинэ.

■ Цэвэрлэсний дараа 2 минут хүртэлх хугацаанд СТТөхөөрөмжид саналын хуудас уншуулахгүй байх

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ДАМЖУУЛАХ ҮЕИЙН АЛДАА

Cell-Go Модем холбоход СТТөхөөрөмж унтрах: Cell-Go модем нь тэжээлийн үүсгүүрээ СТТ-өөс авдаг тул модем холбох үед богино холболт үүсдэг. /Энэ үед Соёмбо тэмдэг гарч гацна/

1. Модемийг СТТ-д залгаатай хэвээр үлдээнэ.
2. Санал тоолох төхөөрөмжийг унтраана.
3. Модемыг Санал тоолох төхөөрөмжид залгаатай хэвээр буцааж асаан, дахин дамжуулах оролдлого хийнэ.



САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ДАМЖУУЛАХ ҮЕИЙН АЛДАА

Cell-Go модем Өгөгдөл дамжихгүй тохиолдолд

- СТТ-д кабелин **шар үзүүр** бүрэн орсон эсэх
- **Цэнхэр үзүүр** модемд бүрэн орсон эсэх
- Тэжээлийн **ногоон гэрэл -1** ассан байх /батарейн зурагтай/
- Сүлжээний **улаан гэрэл-2** анивчиж байх.



Тэжээлийн заагч: Ногоон асна

Сүлжээний заагч:
Улаан анивчина

Өгөгдөл дамжуулалтын
заагч: Ногоон асна



- Өгөгдөл дамжуулалтын **ногоон** гэрэл **3** асахгүй тохиолдолд өгөгдөл дамжуулж буй байрлалаа солих
- Алдаа засагдахгүй бол ойрын GSM сүлжээ бүхий газарт зөөвөрлөн дамжуулах

ЖИ-МОБАЙЛЫН МОДЕМ АШИГЛАН ӨГӨГДӨЛ ДАМЖУУЛАХ



Санал тоолох төхөөрөмж



Модем NP10



Адаптер



LAN кабель

АНХААР: Жи-Мобайлын модемыг **ЗААВРЫН ДАГУУ ЗӨВ** холбож, асааснаас хойш 10 минутын дараа СТТ-тэй холбон өгөгдлөө дамжуулна.

Хэрвээ зааврын холбоогүй бол дүн дамжихгүй бөгөөд тайлан хэвлэгдэхгүй.



САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ДАМЖУУЛАХ ҮЕИЙН АЛДАА

- Дүнг СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн төв серверт амжилттай дамжууллаа гэсэн **ТАЙЛАН** хэвлэнэ. Хэрэв ямар нэгэн тайлан хэвлээгүй бол өгөгдөл дамжаагүй гэсэн үг юм.

ХААСАН

УДИРДЛАГЫН ЦЭС

ДАХИН НЭЭХ

ТУСЛАХ ЦЭС

ДҮНГ ДАХИН
ДАМЖУУЛАХ

УНТРААХ ЦУЦЛАХ

НИЙТ САНАЛ ТОО 8

- Дахин дамжуулах оролдлого амжилтгүй болсон тохиолдолд хамгийн ойрын сүлжээ бүхий газарт зөөвөрлөх. Ингэхдээ СТТөхөөрөмжийг унтраасан байх шаардлагатай.
- СТТ-ийг асаан, **Удирдлагын цэс-с** Дүнг дахин дамжуулах гэж дамжуулна.


БУСАД




- Тэжээлийн эх үүсвэрийг таних
- Огноо тохируулах
- Дэлгэцийн ялгарлыг тохируулах
- Шарагч принтерийн алдаа
- Шарагч принтерийн цаас солих
- Шарагч принтерийн ялгарлын тохиргоо



ТЭЖЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТАНИХ

- СТТөхөөрөмж асаалттай тохиолдолд Led1 анивчина.
- Мөн унтраасан боловч тэжээлийн уртасгагчийг унтраагаагүй тохиолдолд Led1 анивчина.



Тэжээлийн үүсгүүр	Индикатор
Хувьсах 220V	
Нөөц батерей	
Хувьсах 220V болон батерей	

ХУВЬСАХ ТЭЖЭЭЛИЙГ ТӨХӨӨРӨМЖИД ХОЛБОХ










Цахилгааны эх үүсвэрээ “Мотор” –оос авч байгаа бол цахилгааны хэлбэлзэл тогтворжсоны /5-10 минут/ дараа Санал тоолох төхөөрөмжийг залгана.

ОГНОО ТОХИРУУЛАХ



Удирдлагын цэст нэвтэрнэ.








+++ Нэгээр нэмэх,
--- Нэгээр хасах,
ДУУССАН
Дараагийн
тохируулгад
шилжих

ДЭЛГЭЦИЙН ЯЛГАРЛЫГ ТОХИРУУЛАХ




Удирдлагын цэст нэвтэрнэ.



+++ Нэгээр нэмэх,
--- Нэгээр хасах,
ДУУССАН

ШАРАГЧ ПРИНТЕРИЙН АЛДАА



- Хэвлэх команд өгсний дараа ямар нэг хариу үзүүлэхгүй, хэвлэхгүй байх
- Хэвлэх командаар хэвлэж буй боловч хоосон цаас хэвлэх
- Хэвлэсэн тайлангийн ирмэгээр улаан зураас гарах
- Хэвлэсэн тайлан уншигдах боломжгүй хэт бүдэг байх
- Хэвлэсэн тайланд ойлгомжгүй тэмдэгтүүд байх



ШАРАГЧ ПРИНТЕРИЙН АЛДАА

Хэвлэх команд өгсний дараа хэвлэхгүй байх


- Принтерийн ногоон анивчиж буй эсэх. Энэ нь принтерийн ногоон түгжээ HEAD UP байрлалд байгаа бол HEAD DOWN байрлалд оруулах



ШАРАГЧ ПРИНТЕРИЙН АЛДАА


Хэвлэх командаар хэвлэж буй боловч хоосон цаас хэвлэх

- Принтерийн цаас нь зөвхөн нэг тал дээр хэвлэдэг учир цаасыг зөв байрлуулах



Принтерийн цаасыг солих




1. Автоматаар цаас ачаалах
2. Гар аргаар цаас ачаалах



ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ЦААС СОЛИХ

1. Автоматаар цаас ачаалах




- Принтерийн ногоон гэрэл анивчиж байна
- Ногоон түгжээ HEAD DOWN байрлалд байна
- Шинэ цаасыг зурагт үзүүлсний дагуу байрлуулна
- Цаасны үзүүрийг принтерийн бул доогуур хийнэ
- Бул автоматаар эргэж 2 сек -ийн турш цаасыг татна



ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ЦААС СОЛИХ

2. Гар аргаар цаас ачаалах

- Ногоон түгжээ HEAD UP байрлалд байна
- Шинэ цаасыг Зурагт үзүүлсний дагуу байрлуулна
- Цаасны үзүүрийг принтерийн бул доогуур хийнэ. Булыг эргүүлж цаасыг татаж гаргана.
- Ногоон түгжээг **HEAD DOWN** байрлалд оруулна.



HEAD DOWN POSITION



HEAD-UP POSITION

ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ЯЛГАРЛЫГ НЭМЭХ /ТАЙЛАН БҮДЭГ БАЙХ/



Удирдлагын цэст нэвтэрнэ.

НЭЭСЭН

УДИРДЛАГЫН ЦЭС

САНАЛ ХУРААЛТ ХАА

ТУСЛАХ ЦЭС

ХУУДАС ХЯНАХ

УНТРААХ ЦУЦЛАХ

НИЙТ САНАЛ ТОО 8

НЭЭСЭН

УДИРДЛАГЫН ЦЭС

ТАБУЛЯТОРЫН ТУХАЙ

ОНОШИЛГОО

ТАЙЛАНГУУД

ДАХИН ТЭГЛЭХ

ЦУЦЛАХ

НИЙТ САНАЛ ТОО 8

НЭЭСЭН

ТӨХӨӨРӨМЖИЙГ СОНГОНО УУ

САНАХ ОЙ ДОТООД ЦАГ

КОМПАКТ ФЛАШ КАРТ ЭРЧИМ ХҮЧ

EEPROM МОДЕМ

ШАРАГЧ ПРИНТЕР СКАНЕР

LCD ЦУЦЛАХ

НИЙТ САНАЛ ТОО 8

НЭЭСЭН

ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ОНОШИЛГООГ СОНГОНО УУ

ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ТЕСТ

ШАРАГЧ ПРИНТЕРИЙН ЯЛГАРЛЫГ ТОГТООХ

ДУУССАН

НИЙТ САНАЛ ТОО 8

НЭЭСЭН

Принтерийн ялгарлын хэмжээг оруулна уу (0-255)

182

1 2 3

4 5 6

7 8 9

АРИЛГАХ/ЦУЦЛАХ 0 НЭВТРЭХ

НИЙТ САНАЛЫН 5

182-200 тоо оруулах нь тохиромжтой

АНХААРУУЛГА

- Даамлын гарын авлага, хуулийн эмхэтгэлийг унших
- СТТ-ийг хүлээн авах, бүрэн бүтэн байдлыг хариуцах
- Хэсгийн хорооны дарга, зохион байгуулагчтай хамтран ажиллах
- Өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн зааврын дагуу ажиллах
 - Хэсгийн хорооны ажилчид болон ажиглагч нарыг үйл ажиллагаанд оролцуулахгүй байх
 - Тэглэх
- Сонгогчийн саналын хуудсыг харахгүй байх
- Сонгогчийг хүлээлгэнэ, саналын хуудсыг амжилттай уншлаа хүртэл ...
- Мэдээллийн технологийн даамал асуудал тулгарсан үед:
 - 1. Хариуцсан Мэдээллийн технологийн багт мэдэгдэх
- Санал хураалтын өдөр дүнг нэн даруй дамжуулах, зардал шийдэгдсэн байх
- СТТ-ийг МТБ-т бүрэн хүлээлгэн өгөх



**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

ДАДЛАГА АЖИЛ

- Саналын хайрцаг угсрах / Өгөгдөл дамжуулах туршилтын өдөр лацдахгүй /
- СТТ-ийг суурилуулах
- Тэжээлийн залгууруудыг холбох
- Мэдрэгч дэлгэцийн гадаргууг тохируулах
- СТТ-ийг асаах
- Огноог тохируулах
- **Санал хураалт нээх / КОД: 99999999/**
- Тэг тайлан хэвлэх
- Саналын хуудас уншуулах
- Саналын хуудас буцаах тохиолдлууд турших
- СТТ-ийг цэвэрлэх
- Принтерийн цаас солих
- **Санал хураалтыг хаах / КОД: 99999999/**
- Үр дүнгийн тайлан хэвлэх
- Дүн дамжуулах / Мобиком, Юнителийн модем болон Жимобайлын модем ашиглах/
- Дүн дамжуулсан тайлан хэвлэх
- Санал хураалтыг ТЭГЛЭХ /КОД: 1/
/ Өгөгдөл дамжуулах туршилтын өдөр тэгнэлэнэ, санал хураалтын өдөр тэглэхгүй /
- СТТ-ийг унтраах
- Зурган файл хуулбарлах
- СТТ-ийг зөөврийн цүнхэнд хийх